



ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2013 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Үр дүнгийн гэрээний загвар,  
зааварчилга батлах тухай

Монгол улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 134 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төсвийн шууд захирагчийн менежертэй байгуулах үр дүнгийн гэрээний загварыг 1 дүгээр хавсралтаар, Менежерийн мэргэжилтэнтэй байгуулах Үр дүнгийн гэрээний загварыг 2 дугаар хавсралтаар, Харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээний загварыг 3 дугаар хавсралтаар, Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах Үр дүнгийн гэрээний загварыг 4 дүгээр хавсралтаар, Мэргэжилтний Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудасны загварыг 5 дугаар хавсралтаар, Менежерийн Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудасны загварыг 6 дугаар хавсралтаар, Харьяа байгууллагын төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх илтгэх хуудасны загварыг 7 дугаар хавсралтаар, Төсвийн шууд захирагчийн Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх зааврыг 8 дугаар хавсралтаар, Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх зааврыг 9 дүгээр хавсралтаар тус тус баталж, 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгтэй.

2. Үр дүнгийн гэрээг байгуулах, журмын дагуу үнэлж, дүгнэхэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа удирдлагын газар (С.Батболд)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х. ЗОЛЖАРГАЛ